



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
СОНГОЛОН ХАЙРХАН ХХК-ИЙН  
БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Улаанбаатар

2023 он

Батлав. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:  
Сонголон Хайрхан ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Г. Эрдэнэцогт /



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН СОНГОЛОН ХАЙРХАН  
ХХК-ИЙН БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**


/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5276764/

Биелэлтийг тайлагнасан:  
Сонголон Хайрхан ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Г. Эрдэнэцогт /

Сонголон Хайрхан ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн



Б. Эмүжин /

Улаанбаатар хот  
2023 он



## АГУУЛГА

ОРШИЛ .....	3
БҮЛЭГ 1. ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА .....	4
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ .....	4
1.2 ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	4
1.2.1 Үйлдвэрийн байршил, орчны тойм зураг .....	4
1.2.2 Үйлдвэрийн байгууламж .....	4
1.2.3 Үйлдвэрийн хүчин чадал .....	5
1.2.4 Бүтээгдэхүүний найрлага/орцын мэдээлэл .....	6
1.2.5 Үйлдвэрийн үндсэн түүхий эд .....	6
1.2.6 Бетон зуурмагийн нэмэлт бодисын шинж чанар, хор аюул .....	7
1.2.7 Бетон зуурмагт нэмэлт бодис хийхийн давуу тал .....	8
1.2.8 Үйлдвэрийн тоног төхөөрөмж .....	8
1.3 ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЭЦ .....	9
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	10
2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	10
2.2 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	19
2.3 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	20
2.4 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	20
2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	24
2.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	28
2.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	34
ДҮГНЭЛТ	36
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ .....	37



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

## ОРШИЛ

Сонголон Хайрхан ХХК нь Дархан-Уул аймаг, Дархан сум Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаандаа 2022 онд БОННУ тайланг байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний Баялаг Эко ХХК-аар хийлгэж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд улмаар 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Тус 2023 оны БОМТ-нд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн энэхүү биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын 4.1-т заасны дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсрууллаа.



## БҮЛЭГ 1. ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ


Хүснэгт 1-1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Сонголон Хайрхан ХХК</li> <li>• Улсын бүртгэлийн дугаар: 9011179051</li> <li>• Регистрийн дугаар: 5276764</li> <li>• Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг</li> <li>• Утас: +976 98009669 +976 99220394</li> <li>• Цахим шуудан: <a href="mailto:songolon_h@yahoo.com">songolon_h@yahoo.com</a></li> </ul>

### 1.2 ҮЙЛДВЭРИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### 1.2.1 Үйлдвэрийн байршил, орчны тойм зураг


Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлана. Төслийн талбайн хэмжээ 0.8664 га бөгөөд байршлыг



Зураг 1-1-т тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан



Зураг 1-1. Бетон зуурмагийн үйлдвэрийн байршил

Сонголон Хайрхан ХХК нь Талын торгон зам ХХК-иас нэмэлт бодис хадгалах агуулахыг түрээслэн ажилладаг.

### 1.2.2 Үйлдвэрийн байгууламж

Тус үйлдвэр нь оффисын зориулалттай контор, 369 м<sup>2</sup> байр, үйлдвэрлэлийг шууд удирдан хянах 16 м<sup>2</sup> байр зэргээс бүрдэнэ.



Зураг 1-2. Ажилчдын байр



Зураг 1-3. Химийн бодисын агуулах

### 1.2.3 Үйлдвэрийн хүчин чадал

Сонголон Хайрхан ХХК нь чанарын шаардлага хангасан бетон зуурмагийн өвөл зуны нэмэлт бодисыг Талын торгон зам ХХК-тай гэрээ байгуулан худалдан авч, үйл ажиллагаандаа ашигладаг.

Бетон зуурмагийн үйлдвэр нь жилд дунджаар 45 тн химийн нэмэлт бодис хэрэглэдэг. Бетон зуурмагийн үзель нь цагт 90 м<sup>3</sup> бетон зуурмаг зуурах хүчин чадалтай бөгөөд уг үйлдвэрт 4 хүн ажилладаг.



Зураг 1-4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн бүтэц

### 1.2.4 Бүтээгдэхүүний найрлага/орцын мэдээлэл

Бетон зуурмагийн зохистой найрлагыг цементийн анги, дүүргэгчийн шинж чанар, нэмэлтийн төрлөөс хамааруулан тухай бүр зохицуулан сонгодог бөгөөд С7.5-С40 ангийн М100-М500 маркийн хооронд бетон зуурмаг үйлдвэрлэдэг. Үүнд бетон зуурмагийн анги, маркаас хамаарч 1 м<sup>3</sup> бетон зуурмагт ус цементийн харьцаа 0.35-0.53 байх ба 980-1100 кг элс, 740-840 кг дайрга, 160-195 л ус, 260-550 гр цемент, 2.6-5.5 гр нэмэлт бодис тус тус хэрэглэдэг.



### 1.2.5 Үйлдвэрийн үндсэн түүхий эд

Түүхий эд материал цементийг цементвозоор тээвэрлэн зуурмагийн үзелийн цементийн силосонд шахна. 7 хоногийн нөөцтэйгөөр үйл ажиллагаагаа явуулна. Элсийг тусгайлан зассан бетондсон талбайд буулгаж хадгална. Хайрга дайргыг тусгайлан зассан зориулалт бүхий бетондсон талбайд фракц фракцаар нь ангилан буулгаж хадгална. Ойролцоогоор 100,000 м<sup>3</sup>-ийн нөөцтэйгөөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зохицуулалт хийдэг байна.

Үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох цементийг Хөтлийн “Цемент-Шохой” ТӨХК-иес тусгай зориулалтын цементвозоор тээвэрлэж авдаг. Цемент хадгалах 150 тонны багтаамжтай 2 ш, 120 тонны багтаамжтай 1ш силостой мөн 3000-4500 м<sup>3</sup> элс болон дайрга агуулах талбайтай. Дүүргэгч материал болох 0-5 мм элс, 10-20 мм дайргыг өөрийн компанийн элсэн карьер болгон бутлан ангилж боловсруулах үйлдвэрээс авдаг.

Хүснэгт 1-2. Бетон зуурмагт хэрэглэгдэх материалууд

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Нийлүүлэгч	Сарын хэрэгцээ
1.	цемент	П-42,5	Хөтөл “ЦШ” ХК	2000 тн
2.	хайрга, дайрга	5-10,10-20 мм	“Сонголон хайрхан”ХХК карьер	4000 м <sup>3</sup>
3.	элс	0-5 мм	“Сонголон хайрхан”ХХК карьер	3000 м <sup>3</sup>
4.	Нэмэлт	Уян налархайжуулагч, усны орц багасгагч	“Талын торгон зам” ХХК	14 тн

**Дүүргэгч материал:** Дайрганы ширхэгийн хэлбэр нь үндсэн чулуулгийн төрөл, бүтэц болон бутлах төхөөрөмжийн төрөл, ажиллах зарчмаас хамаарна. MNS 0390:1998, MNS 0392:2014 стандартуудын шаардлага хангасан дайрга байх ба энэ тохиолдолд нимгэн үзүүрлэг хэсэг нь 15%-ийн бага буюу 2-5 %-ийн хооронд байдаг. Элсний ширхэгийн модуль нь >2.5 >3.0 байдаг бол 2.68 (том ширхэглэлтэй элс) тоос шавар шорооны хольц 0.4 %-иас ихгүй байдаг.

**Элс:** бетон зуурмагт хэрэглэгдэх элс нь 2.5 мм-с 0.14 мм хүртэл шигшүүрээр шигшигддэг бөгөөд MNS 0392 :2014 стандартын шаардлага хангасан элс юм.

**Нэмэлт бодис:** Бетоны физик- механик чанар (дундаж нягт, бат бөх, удаан эдэлгээт чанар, ус-хүйтэн-хортой үйлчлэл тэсвэрлэх чанар гэх мэт) зэрэг үзүүлэлтүүдийг тохируулах, цемент хэмнэх гэх мэт олон зорилгоор бетонд янз бүрийн нэмэлтийг цементийн жингийн тохирох хувийг нэмнэ. Бетон зурмагт хэрэглэгдэх нэмэлт бодисыг эрдэс гаралтай болон химийн гаралтай нунтаг нэмэлтүүд гэж хоёр ангилна.

- *Химийн нэмэлт:* Бетоны физик-механикийн болон технологийн шинж чанарыг шаардлагатай чиглэлд өөрчлөх үйлчилгээтэй. Усны орц багасгаж, барьцалдах хугацааг удаашруулах нэмэлтүүд лигносульфатын натри, кальци, аммонын давсууд хамаарна.
- *Эрдэс гаралтай нунтаг элементүүд:* эдгээр нэмэлтүүдийн үндсэн хэсэг нь шиллэг төлөвийн цахиурын исэл байна. Энэ исэл нь ердийн нөхцөлд портландцементийн бэхжилтийн үед түүнийг бүрдүүлэгч эрдсүүдийн гидролизоор үүссэн шохойн гидраттай урвалд орж өндөр бат бэхтэй төдийгүй үзүүлэлт сайтай шинэ нэгдэл үүсгэнэ.

MZ-01, MZ-02 бүтээгдэхүүн нь химийн орц найрлагын хувьд поликарбосилатын нийлмэл эфир давамгайлсан бөгөөд натри, кальци, давс бүхий полимерийн нэгдэл юм.

### 1.2.6 Бетон зуурмагийн нэмэлт бодисын шинж чанар, хор аюул

Уян налархайжуулагч болон хүйтний нэмэлт нь аюул ослын тодорхойлолтоор хор хөнөөлтэй гэж тогтоогдоогүй. Харшил өгөх эсвэл их хэмжээгээр тархсан тохиолдолд үрэвсүүлэх магадлалтай





байна. Бүтээгдэхүүний эрүүл мэндийн аюулын ангиллаар XI цочроогч, эрсдэлийн хэв маяг Я43-арсанд хүрсэн тохиолдолд мэдрэмтгий чанар үүсгэнэ.

*Хүснэгт 1-3. Эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөө ба түүний анхны тусламжийн арга хэмжээ*

<b>Эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөө</b>		<b>Анхны тусламжийн арга хэмжээ</b>
<b>Үзүүлэлт</b>	<b>Тайлбар</b>	
Амьсгалахад	Хамрын салстлаг бүрхүүлд харшил өгөх магадлалтай	Амьсгалсан тохиолдолд цэвэр агаарт гарах
Нүдэнд орсон тохиолдолд	Нүдэнд хүрсэн тохиолдолд бага зэргийн харшил өгнө	Нүдээ урсгал усаар 15 минутын турш зайлах, Линзээ авах, нүдээ нээлттэй байлгах
Арьсанд хүрсэн тохиолдолд	Удаан хугацаагаар эсвэл олон удаа хүрсэн үед харшил үүсгэнэ	Бохирдсон гутал хувцсыг нэн даруй тайлах, их хэмжээний урсгал усаар сайтар савандаж угаах
Залгисан тохиолдолд	Бөөлжих, огиудас хүрэх зэрэг шинж тэмдэг илэрч болзошгүй	Амаа усаар зайлж дараа нь ахиухан ус уух
Эмчид өгөх дагалдах бичиг		Эмчилгээг гадаад шинж тэмдгийн дагуу хийнэ

“MZ-01, MZ-02” нь уян налархай байдлыг хадгалах төрлийн суперпластификатор шингэн (химийн нэмэлт бодис) энэ ангилалын нэмэлт нь зуурмагийн уналт сайтай, ус зарцуулалтыг багасгадаг тул бетон зуурмагийн зууралтын үзүүлэлтийг дээшлүүлж бетон цутгалтын болон помпоор шахахад уян налархай гулгамтгай шинж чанартай болдогоос гадна бэхжилтийн явцыг нэмэгдүүлэх тал дээр мөн онцгой сайн үйлчлэл үзүүлдэг. Энэхүү нэмэлтийг энгийн бетон, автопомпоор шахдаг бетон, мөн өндөр маркын, хурдан бэхжидэг бетон зуурмагт өргөнөөр хэрэглэдэг. Ялангуяа өндөр маркын хүнд бетон, угсармал төмөр бетонд тохиромжтой.

#### Онцлог шинж:

- Бетоны урсамтгай чанарын хадгалах хугацааг сайжруулдаг.
- Удаан хугацаанд хол зайнд тээвэрлэх боломжыг бүрдүүлж өгдөг.
- Уян налархайжих чанарын алдагдлыг бууруулдаг.
- Материалийн алдагдлыг бууруулах ба эдийн засгийн хэмнэлт гаргах боломжтой.

#### Хэрэглээ:

- Шахалтын бат бэх өндөр, урт настай байх шаардлагатай гүүр, өндөр барилга байгууламж.
- Шингэн байгалийн хийн бааз, хурдны зам, метроны барилга, туннел г.м байгууламж.
- Үнс, зуухны шаарга, цахиур шороо их хэмжээгээр агуулсан бетон.
- Өөрөө тагтарших бетон зуурмаг.

#### Савлагаа:

1тн –ны хуванцар PVC савлагаатай. MNS ASTM C494/C494 MNS EN 934-1, EN934-2 /Бетонд хэрэглэх нэмэлтийн Техникийн шаардлага/ Бетоны химийн нэмэлтүүд нь стандартын шаардлага хангасан ус, цементийн зарцуулалт багасган бэхжилтийг түргэсгэх, уян налархайжуулах буюу бетон хольцын хөдөлгөөнт чанарыг сайжруулах, хольцийг өөрөө дагтарших чадвартай болгох, бат бэхийг нэмэгдүүлэх үндсэн үйлчилгээтэй. Усны зарцуулалтыг 15-20%-иар бууруулна. Мөн нэмэлттэй бетон ба төмөр бетон бүтээц эдэлхүүнийг уураар бэхжүүлэн хэрэглэж болно. Хлор ионы агууламж, натри хлорийн агууламж нь бага тул гангийн (арматур) зэврэлтээс хамгаална.

#### 1.2.7 Бетон зуурмагт нэмэлт бодис хийхийн давуу тал

Поликарбоксилат төрлийн нэмэлт нь усны хэрэглээг 30 % багасгаж, уян налархайжуулан, бат бэхийг нэмэгдүүлж, нягтаршил сайтай болгодог шинж чанар агуулснаараа бусад төрлийн



нэмэлтүүдийг халж чадсан. Поликарбонат буюу ПИСИ (РС) нэмэлт бөгөөд бетонд нэмэлт хэрэглэснээр  $1\text{ м}^3$  бетонд хэрэглэгдэх усны зарцуулалтыг багасгаж, уян налархайжуулах чанарыг сайжруулж, бат бэхийн үзүүлэлтийг өндөрсгөж, бетонд агаарын агууламжийг үүсгэж бетоны хүйтэн тэсвэрлэлтийг дээшлүүлж, арматурыг зэврэлтээс хамгаалж, ан цав хагарлаас хамгаалан, ус тусгаарлах гэх мэт олон төрлийн үйлчилгээ үзүүлж бетоны механик чадварыг дээшлүүлдэг маш олон талын ашиг тустай. Мөн хүйтний үед бетон доторх ус хөлдөн эзлэхүүнээ тэлсний үлмаас бетоны гадаргууд талст болон ан цав хагарал үүсдэг. Тиймээс агаар үүсгэгчтэй нэмэлтийг хэрэглэснээр бетон дотор нүх сүвний нимгэн хана үүсгэн бетоны хүйтэн тэсвэрлэлтийг дээшлүүлж мөн бетоной ажиллах боломжийг нэмэгдүүлж эдэлгээ, насжилтыг уртасгадаг.

### 1.2.8 Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Хүснэгт 1-4. Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт

№	Тоног төхөөрөмж	тоо	марк	Хүчин чадал
1.	200 тн пресс	1ш	STYE-2000	220V
2.	Автомат шигшүүр	1ш	STSJ-3	220V
3.	Хатаагуур зуух	1ш		220V
4.	1000 нарийвчлалтай жин	1ш	HS420S	-
5.	30кг лабораторийн жин	1ш	JSB30-1	-
6.	Агаар агууламж үздэг багаж	1ш	-	-
7.	Цилиндр сав	3ш	-	2000мл, 500мл, 100мл
8.	Лабораторийн 50л багтаамжтай зуурдаг тогоо	1ш		220V
9.	100×100×100 хэв	30ш		
10.	52м-ын помп	1 ш		
11.	Миксер машин	7 ш		
12.	Бетон зуурах тогоо	1 ш		
13.	Туузан дамжуулагч	1 ш		

### 1.3 ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЭЦ

**Цахилгаан хангамж:** Тус үйлдвэр нь Дархан хотын төвийн шугамаар цахилгааны хэрэглээгээ хангадаг.

**Усан хангамж:** Тус компани нь Дархан-Ус суваг ХК-тай цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээтэй.



## БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан байдаг.

Нөгөө талаас төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

Сонголон Хайрхан ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2023 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 5,857,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2-1. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,250,000
2.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	370,000
3.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,311,000
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	320,000
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,606,000
<b>Нийт зардал</b>		<b>5,857,000</b>

### 2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бетон зуурмагийн агуулахын төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрээр буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усан орчин, ургамлан нөмрөгт тодорхойлж нийт 8 сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2023 оны БОМТ-д тусгасан бөгөөд биелэлтийг Хүснэгт 2-2-т тусгав.



Хүснэгт 2-2. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор авагдсан арга хэмжээний биелэлт, тайлбар
Агаарын чанар			
1.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх	Үйлдвэрийн 0.8 га талбайн сайжруулсан замын тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх	 <p>Зураг 2-1. Үйлдвэрийн талбайн сайжруулсан замын усалгаа хийж буй байдал</p> <p>Үйлдвэрийн талбайн сайжруулсан замын тоосжилтыг бууруулахын тулд зориулалтын усалгааны машинаар усалгааг тоосжилт ихтэй сарууд болох 5-9-р саруудад 10 удаа хийж тоос, шороог дарж, орчны агаарт үзүүлэх нөлөөллийг бууруулж ажилласан бөгөөд нэг удаагийн усалгаанд 20 тн ус ашигладаг. Усыг үйлдвэрийн уснаас авах бөгөөд 2023 онд усны төлбөрт 4,411,275 төгрөг төлсөн.</p>
2.	Тээврийн хэрэгслүүдийн түлшний шаталт агаар орчныг бохирдуулж болзошгүй	Үйлдвэрт хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдээс (миксер) ялгарэх хорт утааг стандартын түвшинд байлгах, хуваарьт үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах	





Зураг 2-2. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ

Үйлдвэрийн хэмжээнд нийт 5 миксер тээврийн хэрэгслүүдтэй бөгөөд эдгээр нь жил бүр техникийн үзлэг оношилгоонд хамрагддаг. Техникийн хяналтын үзлэгт тэнцсэн мэдээллийг smartcar.mn цахим мэдээллийн санд орсон.

### Хөрсөн бүрхэвч

3. Хөрсний эвдрэл

Үйлдвэрээс оффис хүртэл хатуу  
хучилттай болгосон замын арчилгааг  
хийх



Зураг 2-3. Үйлдвэр оффисын байр хоорондын хатуу хучилттай болгосон зам

Үйлдвэрээс оффис хүртэл хатуу хучилттай болгосон замын арчилгааг тогтмол хийдэг.



4. Хөрсний бохирдол үүсэх

Болзошгүй байдлаар шатах тослох материал, бетоны нэмэлт бодис алдагдсан тохиолдолд хэрэглэх саармагжуулах иж бүрдлийн хэрэгслийг нэмж байрлуулах



Зураг 2-4. Гал унтраах болон саармагжуулах хэрэгсэл

Болзошгүй байдлаар шатах тослох материал, бетоны нэмэлт бодис алдагдсан тохиолдолд хэрэглэх саармагжуулах иж бүрдлийн хэрэгслийг байршуулсан. Мөн үйлдвэрийн барилга, байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглах галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2023 оны 04 дугаар сарын 10-ний өдөр аймгийн онцгой байдлын газраар хийлгэж, гаргуулсан. (хавсралтаар оруулав).

5.

Хөрс хог хаягдлаар бохирдох

Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах





*Зураг 2-5. Хог хаягдлын цэвэрлэгээ хийж буй явц*

Хог хаягдлын цэвэрлэгээг үйлдвэрийн талбайн ажилчдын хэмжээнд шаардлагатай үед санаачлан зохион байгуулдаг.

---





6. Хөрс талхлагдах

Тээврийн хэрэгслийн зогсоолд  
хурдны хязгаарлалт болон  
зогсоолын тэмдэг тэмдэглэгээг  
байрлуулах





Зураг 2-6. Авто зогсоолын хурд хязгаарлалтын болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээг

Үйлдвэрийн тээврийн зогсоолд хурд хязгаарлалтын болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.

#### Усан орчин

7. Усны хэт их хэрэглээ үүсэх      Усыг хэмнэх талаар зөвлөмжүүдийг байрлуулах



Зураг 2-7. Усыг хэмнэх талаар зөвлөмж



Үйлдвэрийн ажилчдын байрны угаалтуур болон үйлдвэрийн талбайн гадна усыг хэмнэх, ариг гамтай хэрэглэх уриалга, зөвлөмж байршуулсан.

8. Усны тоолуурын заалтын дагуу Дархан ус суваг ХК-д усны төлбөрийг төлөх Усны тоолуурыг заалтын дагуу Дархан ус суваг ХК-д тогтмол төлдөг (Хавсралт-4).

**Ургамлан нөмрөг**

9. Ногоон байгууламжийн ургалт муудах Үйлдвэрийн хашаанд тарьсан модыг усалж, арчилгаа тордлогоо хийх



*Зураг 2-8. Үйлдвэрийн хашаанд тарьсан модны тордлогоо хийж буй явц*

Үйлдвэрийн хашаанд тарьсан модын усалгаа, арчилгааг тогтмол хийдэг.



## 2.2 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны БОМТ-ний хүрээнд үйлдвэрийн хашаанд 10 ш модыг тарьж, арчилгаа тордлогоо хийж байна. 2023 онд үйлдвэрийн баруун талд 20 ш модыг нэмж тарихаар төлөвлөсөн бөгөөд нийт 370,000 ₮ зарцуулахаар төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний дагуу хавар 20 ш агч модыг нэмж тарьсан.

Хүснэгт 2-3. Ногоон байгууламжийн байршил

№	Цэгийн байршил	
1.	49°25'53.01"N	105°56'32.73"E
2.	49°25'52.94"N	105°56'32.75"E
3.	49°25'53.08"N	105°56'34.43"E
4.	49°25'53.19"N	105°56'34.40"E



Зураг 2-9. Ногоон байгууламжийн төлөвлөлтийн биелэлт



Зураг 2-10. Ногоон байгууламжийн байршил



### 2.3 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК нь үйл ажиллагаа явуулах явцад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасныг баримтлан ажиллахаар төлөвлөгдсөн байна. Үүний дагуу, 2023 оны үйл ажиллагааны хүрээнд төслийн талбай орчимд түүх, соёлын дурсгалт олдвор олдоогүй байна.

### 2.4 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд нийт 6 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Сонголон Хайрхан ХХК нь осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2022 он хүртэлх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Тус үйлдвэрт 2012 онд Эс Эй Эн Ди ХХК-иар 6/0.4 кВ-ын ЦДАШ иж бүрнээр суурилуулсан бөгөөд тэдгээрийн хэвийн ажиллагааг хангаж сар бүр шалгаж ажиллаж байна.
- Бетон зуурмагийн үйлдвэр нь нийт 20 ажилтантай бөгөөд ХАБЭА сургалтыг шинээр ажилтан авах бүрт, мөн жил бүр ХАБЭА давтан сургалтыг зохион байгуулдаг. Үүний дагуу 2022 онд компанийн нийт 20 ажилчдыг ХАБЭА сургалтад хамруулсан байна.
- Сонголон Хайрхан ХХК нь 2022.04.10-ний өдрийн № 12 тоот компанийн дотоод тушаалаар “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс”-ыг байгуулж, асгаралтаас сэргийлэх дотоод журмыг боловсруулан, түүнийг дагаж мөрдөн ажиллаж байна.

Сонголон Хайрхан ХХК нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллахаар 2023 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 1,311,000 ₮ зарцуулахаар төлөвлөсөн.



№	Болзоошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
1.		Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Ажилчдыг хөдөлмөр аюулгүй байдлын зааварчилгааг үргэлжлүүлэн мөрдүүлж ажиллаж байна.
2.		Ажилчдыг үргэлжлүүлэн ХАБЭА сургалтад хамруулах	
3.	Үйлдвэрт ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх	Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрт ажиллах аюулгүйн санамжийн самбар хийлгэж, байрлуулах	



№

Болзоошгүй аюул,  
осол, сөрөг нөлөөлөл

Урьдчилан сэргийлэх, хамгаалах  
арга хэмжээ

Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар



*Хүснэгт 2-5. ХАБЭА сургалтад хамрагдаж буй явц*

Ажилчдыг үргэлжлүүлэн ХАБЭА сургалтад хамруулах, үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрт ажиллах аюулгүйн санамжийн самбар хийж байршуулсан.



№	Болзоошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
4.	Гал түймэр	Үйлдвэрийн галын хорыг цэнэглэж, ажиллагааг хангах	

Зураг 2-11. Үйлдвэрийн галын хор болон галын аюулгүй байдлын дүгнэлт

Үйлдвэрийн галын хорыг цэнэглэж, ажиллагааг нь хангаж ажиллаж байна.





## 2.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд нийт 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Сонголон Хайрхан ХХК нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2022 он хүртэлх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ахуйн, дахин ашиглагдах, аюултай хаягдал гэж ангилан ялгаж, дахин ашиглагдахгүй энгийн хог хаягдлыг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлдэг. Мөн Дархан сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сар бүрт төлдөг.
- Хог хаягдлын цэгийн ойр орчимд сард 2 удаа цэвэрлэгээ, ариутгалыг хийдэг.

*Хүснэгт 2-6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
1.	Ахуйн	Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлэх, актаар хүлээлгэж өгөх	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ахуйн, дахин ашиглагдах, аюултай хаягдал гэж ангилан ялгадаг бөгөөд дахин ашиглагдахгүй энгийн хог хаягдлыг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай 2022.09.01-ний өдөр байгуулсан № 26 тоот гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлдэг. Мөн Дархан сумын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сар бүрд төлдөг.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№ Хог хаягдлын ангилал

Сөрөг нөлөөллийг арилгах,  
бууруулах арга хэмжээ

Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХУРААМЖ (сара)

№	Нэгжийн нэр	Хог үүсгэгч буй хэмжээ	Хураамжийн хэмжээ (төгрөг)	Тайлбар
1.1	Нэг өрхийн, ахуйн хог хаягдлын үйлчилгээний хураамж	-	5,000	Сар бүр Тогтмол
1.2	Өрхийн хашаандаа болон орон сууцны 1 дүгээр давхар, зэвсгийн давхарт үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамж	Бага	10,000-24,999	Сар бүр Тогтмол
		Дунд	25,000-49,999	Сар бүр Тогтмол
		Их	50,000-100,000	Сар бүр Тогтмол
1.3	Орон сууцны хорооллын дунд байрлах тусгай объектод үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамж	Бага	10,000-29,999	Сар бүр Тогтмол
		Дунд	30,000-49,999	Сар бүр Тогтмол
		Их	50,000-100,000	Сар бүр Тогтмол
1.4	Дундагчлан тээвэрлэлтээр өчих тариф	-	15,000	м/хүб
1.5	Түрж булж устгах үйлчилгээний хураамж	-	10,000	м/хүб

—00—

Зураг 2-12. Хог хаягдлын тээвэрлэлтийн хураамж бичиг

2.

Хог хаягдлын бүртгэл хөтөлх


“Сонголон хайрхан”  
ХХК-ийн Аюултай  
хог хаягдлын  
бүртгэл

№	Ор, сар, өдөр	Нэр тэрэг	Тайлбар
67	2023-07-14	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
68	2023-07-16	Аюултай, Дархан-Уул	0.18 / 0.18
69	2023-08-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
70	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	— / —
71	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
72	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
73	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
74	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
75	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
76	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178
77	2023-11-01	Аюултай, Дархан-Уул	0.178 / 0.178

Хүснэгт 2-7. Аюултай хог хаягдлын бүртгэлийн дэвтэр

Аюултай хог хаягдлын бүртгэлийн дэвтэртэй бөгөөд цаг тухайд нь хөтөлж, гэрээт компаниар тээвэрлүүлж, устгуулдаг.




№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
3.		Хогийн сав болон цэгийг цэвэрлэх	

Зураг 2-13. Хогийн цэг түүний ойр орчимд цэвэрлэгээ хийж буй явц

Хог хаягдлын цэгийн ойр орчимд сард 2 удаа цэвэрлэгээ, ариутгалыг хийдэг.



№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Авсан арга хэмжээний биелэлт, тайлбар
4.	Аюултай	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас гарсан дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав, зэрэг аюултай хог хаягдалд хамаарах үүссэн аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад нийлүүлж, устгуулах	 <p data-bbox="1227 724 1827 746">Зураг 2-14. Хог хаягдлыг ангилан цуглуулах сав, хогийн цэг</p> <p data-bbox="1021 772 2033 858">Тээврийн хэрэгслийн ашиглалтаас гарсан дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав зэрэг аюултай хог хаягдалд хамаарах үүссэн аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад нийлүүлж устгуулсан.</p>



## 2.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Агаарт орчны тоосжилт, агаар бохирдуулагч хийг тодорхойлуулсан
- 3 цэгээс дээж авч хөрсний ерөнхий хими болон хүнд металлыг тодорхойлуулсан
- Ургамлын мониторингийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн.

2023 оны БОМТ-нд Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг доорх хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр нь үйлдвэрийн талбайд агаар, хөрс, усны шинжилгээг жилд 2 удаа хийх
- Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр нь хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1 удаа хийлгэх

*Хүснэгт 2-8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Агаарт орчны тоосжилт (PM2.5, PM10 TSP)	2023 оны 04-р сарын 25-27-ны хооронд хөрс, ус, агаарын хэмжилтийг Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн. Шинжилгээний хариуг хавсралтад оруулав.	100 %
2.	Хөрсөн бүрхэвчид ерөнхий үзүүлэлт болон хүнд металлыг тодорхойлуулах		100 %
3.	Усны шинжилгээ		100%

### Агаарын чанар.

Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор үйлдвэрийн агаарыг шинжлүүлэхэд агаарт агуулагдах хүхэрлэг хий, азотын давхар исэл болон нийт тоосны агууламж нь агаарын чанарын MNS: 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтгүй байв.






Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан



Зураг 2-15. Гадаад хяналт шинжилгээний үйл явц



Зураг 2-16. Дотоод хяналт шинжилгээний үйл явц



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

Хүснэгт 2-9. Үйлдвэрийн орчимд хийсэн агаарын хэмжилтийн үр дүн

Үзүүлэлт	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> /	Азотын давхар исэл (NO <sub>2</sub> )	Нийт тоосонцор (TSP)
Хайрга ангилах хэсэг	11	36	339
Бетон зуурмаг үйлдвэрийн хэсэг	9	22	220
<b>MNS 4585:2016</b>	<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>

Үйлдвэрийн агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл нь агаарын чанарын MNS: 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлтгүй байна.

2023 оны 9-р сард үйлдвэрийн талбайд агаарын хэмжилтийг DustTrack 850 загварын багажаар агаарт агуулагдах тоосонцрын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Үйлдвэрийн агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламжийг доорх графикт тусгав.



График 2-1. Үйлдвэрийн талбайд хийгдсэн хүхэрлэг хийн агууламж




График 2-2. Үйлдвэрийн талбайд хийгдсэн азотын давхар исэлийн агууламж



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан




График 2-3. Үйлдвэрийн талбайд хийгдсэн нийт тоосны агууламж

Хүснэгт 2-10. Агаарын чанарын хэмжилтийн дүн

Үзүүлэлт	Агаарын чийгшил	Агаарын температур	Салхины хурд
Хайрга ангилах хэсэг	14	8.4°C	6 м/с
Бетон зуурмаг үйлдвэрийн хэсэг	14	8.7°C	7 м/с

**Хөрсөн бүрхэвч.**

Сонголон Хайрхан ХХК нь 2023 оны 09 дүгээр сард үйлдвэрийн хашаан доторх хөрснөөс дээж авч Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн байна. Үйлдвэрийн орчны хөрснөөс ялзмаг, нитрат, сульфат, аммони, урвалын орчин, цахилгаан дамжуулах чадвар зэргийг шинжлэхэд тухайн хөрс нь MNS: 3297:2019. Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй байсан.

Хүснэгт 2-11. Дээж авсан байршил

№	Дээжийн дугаар	Авсан байршил
1.	Дээж – 1	Үйлдвэрийн орчин
2.	Дээж – 2	Бетон зуурмаг үйлдвэрийн хэсэг

Хөрсний дээжлэлт хийж буй явцыг доорх зурагт үзүүлэв. Хөрсний шинжилгээний үр дүнд гарсан хариуг Хүснэгт 2-12-т тусгав.

Хүснэгт 2-12. Үйлдвэрийн талбайгаас авсан хөрсний дээжийн хариу

Шинжилгээний аргын стандарт	Хөрсний химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 3297:2019	Үйлдвэрийн орчин	Бетон зуурмаг үйлдвэрийн хэсэг
MNS 3310:91	Хөрсний ялзмаг	%	-	1.33	1.36
	Нитрат, NO <sub>3</sub>	мг/кг	130	23.9	13.6
	Сульфат, SO <sub>4</sub>	мг/кг	160	64.9	47.5
	Аммони, NH <sub>4</sub>	мг/кг	-	25.4	11.3
	pH	-	-	7.38	9.03
	ЕС	µS/cm	-	543.0	491.0





Зураг 2-17. Хөрсний дээжлэлт, Бетон зуурмаг үйлдвэрийн хэсэг



Зураг 2-18. Хөрсний дээжлэлт, Үйлдвэрийн орчин




График 2-4. Хөрсөнд агуулагдах Сульфатын хэмжээ




График 2-5. Хөрсөнд агуулагдах Сульфатын хэмжээ

Хөрсний сорьц дээжийг диагоналийн аргаар авсан ба тухайн дээжийн хариунд, хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 3297:2019 стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтээр нитрат /NO<sub>3</sub>/-ын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

#### Ургамлан нөмрөг.

Үйлдвэрийн талбайд 6-р сард ургамлын мониторинг хийсэн.



Зураг 2-19. Ургамлын мониторинг хийж буй явц

Талбайд 1x1 метр квадрат хэмжээтэй Раменскийн торыг ашиглан Браунбланкийн арга зүйд тулгуурлан геоботаникийн бичиглэл хийж ургамлын зүйлийн бүрдэл, тусгагийн бүрхцийг тодорхойлсон бөгөөд 1x1 квадрат метр талбайд:

- ургамлан бүрхэц 90 орчим хувь,
- чулууны бүрхэц 3 хувь,
- хагдны бүрхэц 2 хувь,
- халцгай газрын бүрхэц 5 хувь байсан.

Бетон зуурмагийн үйлдвэр орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалтыг доорх хүснэгтэд тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

Хүснэгт 2-13. Бетонон зуурмагийн үйлдвэрийн талбай орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалт

№	Ургамлын монгол нэр	Ургамлын латин нэр	Найлзуурын өндөр, см	Фенологийн үе шат
<b>Asteraceae</b>				
1.	Адамсийн шарилж	<i>Artemisia Adamsii Bess.</i>	6.5	Ургалтын үе
2.	Ямаан шарилж	<i>Artemisia scoparia Waldst. et Kit.</i>	9.2	Ургалтын үе
3.	Маралхай шарилж	<i>Artemisia tanacetifolia L.</i>	7.9	Ургалтын үе
4.	Эмийн багваахай	<i>Taraxacum officinale Wigg.</i>	8.1	Цэцэглэлтийн үе
<b>Brassicaceae</b>				
5.	Бүхэл навчит багдай	<i>Dontostemon integrifolius (L.) C.A.Mey.</i>	8.7	Цэцэглэлтийн үе
6.	Бууралдуу янгиц	<i>Ptilotrichum canescens C.A.Mey.</i>	7.4	Ургалтын үе
<b>Cyperaceae</b>				
7.	Ширэг улалж	<i>Carex duriuscula C.A.Mey</i>	4.3	Ургалтын үе
<b>Plantaginaceae</b>				
8.	Их таван салаа	<i>Plantago major L.</i>	6.7	Ургалтын үе
<b>Poaceae</b>				
9.	Саман ерхөг	<i>Agropyron cristatum (L.) P. B</i>	11.8	Ургалтын үе
10.	Нарийн цагаан суль	<i>Elymus angustus Trin</i>	7.6	Ургалтын үе
<b>Rosaceae</b>				
11.	Ишгүй гичгэнэ	<i>Potentilla acaulis L.</i>	3.2	Ургалтын үе

Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайд дэрс-харгана-шарилжит бүлгэмдэл зонхилсон. Талбайд нийт 6 овгийн 9 төрлийн 11 зүйл дээд ургамал бүртгэгдсэн. Талбайд ховор болон нэн ховор ургамал бүртгэгдээгүй.

## 2.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд нийт 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2022 оны БОМТ-ний удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Ажилчдад ХАБЭА, үйлдвэрийн осол, химийн бодистой харьцах зэрэг сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулдаг.
- Сонголон Хайрхан ХХК нь Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран үйлдвэрийн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг бөгөөд хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангадаг.


2023 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг доорх хүснэгтэд тусгав.

Хүснэгт 2-14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлтийн тайлбар
1.	Байгаль орчны аудитыг хийлгэх	“Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10 <sup>1</sup> дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллага болох Энвайроментал Комплайнц ХХК-р хийлгүүлсэн (хавсралтад оруулав).
2.	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулах	Ажилчдад мэргэжлийн байгууллагатай хамтран ХАБЭА сургалт тогтмол зохион байгуулдаг.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлтийн тайлбар
		 <p data-bbox="810 1102 1337 1160"><i>Зураг 2-20. Мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулж буй</i></p>
3.	Ажилчдыг үргэлжлүүлж эрүүл мэндийн үзлэгт хамруулах	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан бөгөөд биелэлтийн тайланг 11-р сарын 01-ны өдрөөс өмнө цахим мэдээллийн санд оруулсан.
	<b>Биелэлтийн хувь</b>	<b>100%</b>



## ДҮГНЭЛТ

Сонголон Хайрхан ХХК нь Бетон зуурмагийн үйлдвэрийн 2023 оны БОМТ-нд тусгагдсан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Үйлдвэрийн 0.8 га талбайн сайжруулсан замын тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийсэн
- Үйлдвэрт хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдээс (миксер) ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, хуваарьт үзлэг, оношилгоонд хамруулсан
- Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулсан
- Тээврийн хэрэгслийн зогсоолд хурдны хязгаарлалт болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан
- Усны тоолуурын заалтын дагуу Дархан ус суваг ХК-д усны төлбөрийг тогтмол төлдөг
- Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлдэг
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлсэн гэх мэт үйл ажиллагаануудыг гүйцэтгэсэн байна.

<i>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг</i>	<b>Хийх ажлын тоо</b>	<b>Хийсэн ажлын тоо</b>	<b>Биелэлт (%)</b>
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	9	9	100
Ногоон байгууламжын төлөвлөгөөний биелэлт	1	1	100
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	4	4	100
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	4	4	100
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	3	3	100
Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	3	3	100
<b><i>Нийт</i></b>	<b>24</b>	<b>24</b>	<b>100</b>

Сонголон Хайрхан ХХК нь Бетон зуурмагийн үйлдвэртээ 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 24 ажлыг хийж гүйцэтгэн, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр амжилттай ажилласан байна.



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

## ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хавсралт-1: Галын аюулгүй байдлын дүгнэлт

Огноо: 2023 оны 04 дунд сарын 10-ны өдөр  
N154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ДҮГНЭЛТ**

дугаар: **0010031**

**Сонголон хайрхан ХХК**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: .....

**Дархан сум 13-р баг Үйлдвэрийн район**

Хаяг: .....

**Барилгын материал**

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: .....

**Худалдаа үйлдвэрлэл**

Барилга байгууламжаа гал унтрах тусгай төхөөрөмж, гал унтрах автомат болон  
дохиролт систем, утга залуулах систем, усны хангамж /дархан шилэн бэлгэц хэрэглэж,  
барилга материалыг хэргийг байрлуулсан ашиглахад нэгжүү дүгнэлтийг олгоно.  
Галын аюулгүй байдлыг тухай хуулийн 6 дугаар зүйлсийн 6.1.3

Огноо: **2023 04 10**  
Он . . . . . сар . . . . . өдөр

Хуучинтай хугацаа: **2025 04 09**  
Он . . . . . сар . . . . . өдөр хүртэл

Дүгнэлт өгсөн: **Дархан-Уул**  
аймаг, нийслэл /сүм, сум, байрны газар /хэлтсийн/  
Хурандаа **С.Нүрэвсамдан**  
артай . . . . .

Дүгнэлт гаргасан: **Дархан-Уул**  
аймаг, нийслэл /сүм, сум, байрны газар /хэлтсийн/  
**Хошууч Ц.Идэш**  
артай . . . . .

Гал түймрийн улсын хяналтын байцаагч: .....

ГЭМЭХ ЗЕРГЭД





Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

**Хавсралт-2: Агаарын хэмжилтийн шинжилгээний хариу**



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ**



Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр  
Утас: 7037-3783, 70374161  
E-mail: info@darkhan-uul.namem.gov.mn

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН**

Дугаар он/№ : 2023/1-15  
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "СОНГОЛОН ХАЙРХАН" ХХК  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Э.Сайнзаяа, БОШЛ-ийн технологич инженер  
Сорьцын тоо, төрөл : 3 цэг, агаарын бохирдлын шинжилгээ  
Сорьц авсан огноо : 2023.04.25  
Шинжилсэн огноо : 2023.04.26  
Хуудасны тоо : 1/3

№	Шинжилгээний аргачлал	Агаарын шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 4585:2016 1 удаагийн сорьцын ХА	Хэмжилт хийсэн цэг 20 минутын сорьцын дундаж агууламж /давтамж 3/		
					10401й	10402й	10403й
1	MNS 0017-2-5-12:2021	Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> /	мкг/м <sup>3</sup>	450	11	9	4
2	MNS 0017-2-5-11:2021	Азотын давхар исэл /NO <sub>2</sub> /	мкг/м <sup>3</sup>	200	36	22	16
3	MNS4048-88	Нийт тоос /20 мин/	мкг/м <sup>3</sup>	500	339	220	89

Товчилсон үг: ХА-хүлцэх агууламж  
Сорьцын код: 10401й- Үйлдвэрлэлийн орчин-Хайрга ангилах хэсэг  
10402й- Үйлдвэрлэлийн орчин-Бетон зуурмаг үйлдвэрийн хэсэг  
10402й- Элсэн карьерын орчин

**Тайлбар:**

1. Тухайн сорьц авах, хэмжилт хийх хугацааны цаг агаарын нөхцөл: Агаарын чийгшил 14%, агаарын температур 8.4 -...8.7 градус дулаан, салхи хойноосоо 6-7м/с хурдтай байсан.
2. Агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж агаарын чанарын MNS4585:2016 стандартын 1 удаагийн сорьцын ХА-аас давсан бохирдолгүй.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:  
БОШЛ-ИЙН АГААРЫН ТЕХНИКЧ  Ө.АЛТАНЗУЛ  
ХЯНАСАН:  
БОШЛ-ИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР  Э.САЙНЗАЯА  
БАТАЛГААЖУУЛСАН:  
УОШХ-ИЙН ДАРГА  М.АЛИМАА

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

Хавсралт-3: Хөрсний дээжлэлтийн шинжилгээний хариу



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ЛАБОРАТОРИ

Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр  
Утас: 7037-3783, 70374161  
E-mail: info@darkhan-uul.namem.gov.mn



### ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2023/3-10  
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "СОНГОЛОН ХАЙРХАН" ХХК  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Э.Сайнзаяа, БОШЛ-ийн технологич инженер  
Сорьцын тоо, төрөл : 3 цэг, хөрсний химийн шинжилгээ  
Сорьц авсан огноо : 2023.04.25  
Шинжилсэн огноо : 2023.04.25-27  
Хуудасны тоо : 3/3

№	Шинжилгээний аргын стандарт	Хөрсний химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 3297:2019 ЗДХ	Үзүүлэлтүүд		
					30401и	30402и	30403и
1	MNS3310:91	Хөрсний ялзмаг	%		1.33	1.36	2.34
2		Нитрат, NO <sub>3</sub>	мг/кг	130	23.9	13.6	3.5
3		Сульфат, SO <sub>4</sub>	мг/кг	160	64.9	47.5	30.2
4		Аммони, NH <sub>4</sub>	мг/кг		25.4	11.3	13.6
5		РН			7.38	9.03	6.95
6		ЕС	µS/cm		543.0	491.0	352.0

Товчилсон үг: ЗДХ - зөвшөөрөгдөх дээд хэмжээ  
Дээжийн код: 30401и- Үйлдвэрлэлийн орчин  
30402и- Бетон зуурмаг үйлдвэрийн хэсэг  
30403и- Карьерийн хэсэг

Тайлбар:

- Хөрсний сорьц авсан арга: Диагоналийн арга
- Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS3297:2019 стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтээр нитрат /NO<sub>3</sub>-ын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолгүй.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:  
БОШЛ-ИЙН ИНЖЕНЕР Г.АНХМАА  
ХЯНАСАН:  
БОШЛ-ИЙН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР Э.САЙНЗАЯА  
БАТАЛГААЖУУЛСАН:  
УОШХ-ИЙН ДАРГА М.АЛИМАА

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна





Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

Хавсралт-4: Усны төлбөр төлсөн баримт

www.Darkhan-ussuvag.mn

**УСНЫ ТООЦООНЫ НЭХЭМЖЛЭХ** "ДАРХАН-УС СУВАГ" ХК/Регистрийн № 2736012

Аж ахуйн нэгжийн нэр: *Сонголон хайрхан ХХК* Албан тушаалтны нэр: \_\_\_\_\_ КОД *00226039*  
Бодолтын сар: 20*23* оны *09* сар Нэхэмжлэх бичсэн: 20*23* оны *09* сар *15* өдөр

С-Эхний үлдэгдэл: *2*

Д-Урьд сарын үлдэгдлээс төлсөн усны төлбөр: \_\_\_\_\_ төг \_\_\_\_\_ мөнгө *₮ 5246464*

№	Тоолуурын байршил	Эхний заалт	Эцсийн заалт	Цэвэр усны дүн (м³)	№	Нэр төрөл	Цэвэр усны шугамын диаметр	Хэмжээ (м³)	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ (төг)
Хүтэн ус, ялтсан халаагчийн усны тоолуур		<i>5253</i>	<i>5352</i>	<i>99</i>	1	Суурь хураамж				<i>22560</i>
		<i>1349</i>	<i>1391</i>	<i>42</i>	2	Цэвэр ус		<i>411</i>	3060	<i>431460</i>
		<i>424</i>	<i>425</i>	<i>2</i>	3	Бохир ус			3300	<i>2</i>
					4					
					5	Маягтны үнэ			250.00	250.00
					6	Дүн (1+2+3+4+5)				<i>454240</i>
					7	НӨАТатвар (6*10%)				<i>27254</i>
					8	Усны нөөц татвар	<i>165,24</i>			<i>23323,44</i>
					9	Тухайн сарын төлбөр				<i>5246464</i>
					10	Эцсийн үлдэгдэл (с-д+9)				

Бүгд цэвэр усны дүн \_\_\_\_\_ төг \_\_\_\_\_ мөнгө *₮ 411*

1. Каргиер банк-2037001014 2. Чингис хаан банк-3920111003 3. ХААН банк-5045052676  
4. Улаанбаатар банк-4501824023 5. Капитрон банк-3006002504 6. Худалдаа хөгжлийн банк-403001122  
7. Төрийн банк-19089093249 тоот дансанд тушаана уу.

Аж ахуйн нэгжийн газартай тус тусын үсэг: \_\_\_\_\_ /  
Усны биологийн санхүүжилтийн гарын үсэг: \_\_\_\_\_ /

\_\_\_\_\_ /, утасны дугаар \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ /, утасны дугаар *80203760*

*Талсан*

www.Darkhan-ussuvag.mn

**УСНЫ ТООЦООНЫ НЭХЭМЖЛЭХ** "ДАРХАН-УС СУВАГ" ХК/Регистрийн № 2736012

Аж ахуйн нэгжийн нэр: *Сонголон хайрхан* Албан тушаалтны нэр: \_\_\_\_\_ КОД *00226039*  
Бодолтын сар: 20*23* оны *10* сар Нэхэмжлэх бичсэн: 20*23* оны *10* сар *16* өдөр

С-Эхний үлдэгдэл: *2*

Д-Урьд сарын үлдэгдлээс төлсөн усны төлбөр: \_\_\_\_\_ төг \_\_\_\_\_ мөнгө *₮ 5246464*

№	Тоолуурын байршил	Эхний заалт	Эцсийн заалт	Цэвэр усны дүн (м³)	№	Нэр төрөл	Цэвэр усны шугамын диаметр	Хэмжээ (м³)	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ (төг)
Хүтэн ус, ялтсан халаагчийн усны тоолуур		<i>5352</i>	<i>5451</i>	<i>99</i>	1	Суурь хураамж				<i>22560</i>
		<i>1391</i>	<i>1442</i>	<i>51</i>	2	Цэвэр ус		<i>153</i>	3060	<i>468180</i>
		<i>424</i>	<i>430</i>	<i>3</i>	3	Бохир ус			3300	
					4					
					5	Маягтны үнэ			250.00	250.00
					6	Дүн (1+2+3+4+5)				<i>490990</i>
					7	НӨАТатвар (6*10%)				<i>49099</i>
					8	Усны нөөц татвар	<i>165,24</i>			<i>25373,52</i>



**Хавсралт-5: Байгаль орчны аудитын үйлчилгээ авах гэрээ**

**ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны 09-р сарын 30 өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол, Юнескогийн гудамж –31, Далай Тауэр, 402 тоотод тоотод байрлах Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Энвайронментал комплайнц” ХХК (цаашид “Компани эсхүл Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж захирал Б.Энхбаяр,

нөгөө талаас Монгол улс, Дархан-Уул аймаг Дархан сум 13 дугаар баг өмнөд үйлдвэрийн район өөрийн байранд байрлах, Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Сонголон хайрхан” ХХК (цаашид “Захиалагч”), түүнийг төлөөлж захирал Г.Эрдэнэцогт бид нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 зүйлүүдийг үндэслэн дараах нөхцөл бүхий гэрээг харилцан тохиролцож (цаашид “Гэрээ” гэх) байгуулав

**1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ**

1.1. Гэрээлэгч нь Захиалагчийн Дархан-уул аймгийн Дархан сумын нутагт байрлах бетон зуурмагийн үйлдвэр болон Дархан-Уул аймгийн Орхон сумын нутагт байрлах их булангийн элс хайрганы төслийн үйл ажиллагаанд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” –ийн 10<sup>1</sup> дугаар зүйлд заасны дагуу байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит хийж, улмаар төслийн одоогийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, засаж сайжруулах зүйлс, авах арга хэмжээ, цаашид байнгын сайжруулах боломж бий болгож улмаар Захиалагчид учирч болзошгүй эрсдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх болон орон нутгийн иргэд, ажилчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бий болгоход нь тусалж дүгнэлт, зөвлөмж өгөх нь энэхүү аудитын ажлын үндсэн зорилго оршино.

1.2. **Үйлчилгээний тайлбар:** Байгаль орчны төлөвлөгөөт аудит

1.3. **Байршил** Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах бетон зуурмагийн үйлдвэр болон Дархан-Уул аймгийн Орхон сумын нутагт байрлах их булангийн элс хайрганы төсөл

1.4. **Үйлчилгээ үзүүлэх гэрээний:**

**Эхлэх хугацаа:** 2023 оны 10-р сарын 10-ний өдөр /БОА-н үйлчилгээ гэрээний урьдчилгаа төлбөр төлөгдсөн өдрөөр эхлэнэ./

**Дуусах өдөр:** 2023 оны 10-р сарын 25-ны өдөр хүртэл.

1.5. **Гүйцэтгэх ажлын үндсэн чигэл:**



Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байрлах  
Сонголон Хайрхан ХХК-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
биелэлтийн тайлан

**Хавсралт-6: Хог хаягдлын гэрээ**



2022 оны 9 сар 1 өдөр №26 Дархан-Уул аймаг

Иргэн, ААН байгууллагын нэр	"Сонголон Хайрхан" ХХК	
Регистерийн дугаар		
Үйл ажиллагааны чиглэл	Борилгоны үйлчилгээний үйлдвэрлэл	
Иргэн, ААНБ-ын хаяг		
ААНБ-ын холбогдох утас	99102201, 9902	
Данс	100190100947 - Түрмийн 5608267520 - Халх Банк	
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл	Сард .....төгрөг	Рейсийн тоогоор 1 рейс ..... Төгрөг
Төлбөрийн нөхцөл		
Гэрээний хугацаа	2022 оны 9-р сарын 1-ны өдрөөс 2023 оны 9-р сарын 1-ны өдөр хүртэл	
Гэрээний сунгалт		

Гүйцэтгэгч талаас "Дархан Хот Тохижилт Үйлчилгээний Газар" ОНӨААТҮГ-ыг төлөөлж Ахлах байцаагч Даш-ёндон овогтой Нарантуяа Нөгөө талаас ..... Д. .... овогтой ..... цаашид захиалагч тал гэх/ нар нь "Монгол Улсын Хог Хаягдлын тухай хууль", "Зөрчлийн тухай хууль" эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь ААНБ-аас гарч байгаа ахуйн болон аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх түрж булж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

**Хоёр. Гүйцэтгэгч талын эрх үүрэг**

- 2.1 Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй
- 2.2 Хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй
- 2.3 хог тээврийн машин орж ачих боломжгүй байршилд байгаа, тогтоосон цэгт төвлөрүүлээгүй, хог тээврийн хураамжаа тайлант хугацаанд төлөөгүй, хуримтлагдсан өртэй ААНБ-ын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.4 Хог хаягдлын тухай хууль тогтоомжуудыг үндэслэн хог хаягдлаа ачиж тээвэрлүүлэх, зориулалтын зөвшөөрөгдсөн цэгт хаяхыг шаардах эрхтэй
- 2.5 хог хаягдлыг дуудлагаар буюу графикт хугацаанд гэрээний дагуу ачих үүрэг хүлээнэ.
- 2.6 Ажлын ачаалал, цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч графикт хугацаанд хогийг ачиж тээвэрлэж чадахгүй бол урьдчилан мэдэгдэнэ.